



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

197 /1971

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.12.09

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр

1982 он.

## НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ЗДТГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА

АИХ-ын 292 тоот зарлигаар Бүх цэргийн дуу бүжгийн чуулга Байлдааны гавьяаны Улаан тугийн одонгоор шагнагдав.



Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч хурандаа Ж.Болдбаатараар ажлын хэсэг нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга нар, алба хаагчидтай уулзаж, орон нутгийн батлан хамгаалахын хууль, тогтоомжийн биелэлт, Цэргийн штабуудын эрхлэх асуудлын хүрээний ажилтай танилцлаа.

Энэ хүрээнд нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын алба

хаагчдад Батлан хамгаалах яамнаас хэрэгжүүлж байгаа ажлуудыг видео хэлбэрээр танилцуулж, салбарын сайдын хэрэгжүүлж буй ажлыг орон нутагт хэрхэн сурталчилж байгаа, цэргийн алба хаагчдын ёс зүй, сахилга, дэг журам, хариуцлагыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажил болон батлан хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилт, хяналт шалгалт зохион байгуулж байгаатай танилцаж тухай бүрд нь үүрэг, чиглэл өгч ажиллалаа. Мөн энэ үеэр НЗДТГ-

ын Цэргийн штабын дарга хурандаа Г.Ялалт 2021 онд хийж хэрэгжүүлсэн ажлынхаа талаар тайлагнасан юм.

Тэрээр "Батлан хамгаалах бодлого зорилт, үйл ажиллагаа, хууль тогтоомжийг орон нутагт сурталчлах, хэрэгжүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэхэд чиглэж ажиллалаа. Бид 2021 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг амжилттай зохион байгуулсан. Мөн цэргийн алба хаагчдын дархлаажуулалтыг дэмжин, анги байгууллагатай

хамтран ажиллаж, тэдэнд нийслэл, дүүргийн ЗДТГ-аас тодорхой хөрөнгө мөнгийг шийдүүлж, витаминжуулалт болон дархлаажуулалтын багцыг тусламж болгон өгсөн. Цаашлаад 2022 онд цэргийн бүртгэлийг "E-Mongolia" аппалкейшн ашиглан цахим хэлбэрээр явуулах нөхцөлийг судалж байна. Яриа хэлэлцээрийн түвшинд бэлтгэл ажил өндөр хувьтай байгаа. Эцсийн байдлаар ажил хэрэг болгохыг зорьж байна" гэв.

### ЦАГ АГААР

#### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-5	-19

#### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	24

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,844.0	2,855.0
EUR	3,182.0	3,253.0
CNY	446.00	450.50
RUB	37.80	39.80
JPY	24.75	25.39
KRW	2.34	2.47

### ЗУРХАЙ

2021.12.09 ПҮРЭВ ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 06/

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өнгө зүс сайжирна  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
08.30-16.59

Барилдлага:  
Үл зохилдох

Шүтэн барилдлага:

Нэр өнгө  
Суудал:  
Хий

Энэ өдөр гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба гарагийг тахих, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, улаа гаргах, хиншүү хярвас гаргах, уул овоо тахихад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өнгө зүс сайжирна.

Үс засуулбал ӨНГӨ ЗҮС сайжирна



Зэвсэгт хүчний Барилга-Инженерийн цэргийн удирдах газрын 2021 оны үйл ажиллагааны тайлангийн хурал өчигдөр боллоо. Тайлангийн хуралд ЗХЖШ-ын орлогч дарга бригадын генерал Ч.Цогтжаргал, ХШҮГ-ын даргын орлогч дэд хурандаа Г.Амартүвшин, Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын бие бүрэлдэхүүн оролцлоо. Мөн тус газрын харьяа Зэвсэгт хүчний 017, 110, 338, 339, 340, 7780, 7781, 7782 дугаар ангийн захирагч нар цахимаар оролцсон юм.

Хурлын эхэнд Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын харьяа Зэвсэгт хүчний 017, 338, 110, 339, 340, 7780, 7781, 7782 дугаар ангийн 2021 оны онцлох бүтээл ажлуудын үзэсгэлэн болон видео бичлэгтэй танилцав.

Үргэлжлүүлээд 2021 оны үйл ажиллагааны тайланг тус газрын

дарга хурандаа Х.Батсайхан илтгэж, тайлантай холбоотой санал, шүүмжлэлийг сонсож ирэх оны зорилго, зорилтуудаа тодорхойлон дүгнэн ярилцсан юм.

Төгсгөлд нь ЗХЖШ-ын орлогч дарга бригадын генерал Ч.Цогтжаргал "Зэвсэгт хүчний Барилга-Инженерийн цэргийн удирдах газрын хувьд 2021 он шинэ шат, ахиц дэвшилд хүрсэн жил байлаа. Үүнийгээ улам сайжруулахын зэрэгцээ 2024 он хүртэл улс орны стратегийн бүтээн байгуулалтын ажилд ханцуй шамлан оролцох том ажил та бүхнийг хүлээж байна. Мөн ЗХЖШ-аас шинээр байгуулагдаж буй Зэвсэгт хүчний 341, 342 дугаар ангиудын хүний нөөцийн нөхөн хангалтыг богино хугацаанд шийдвэрлэх талаар анхаарал хандуулж ажиллана" хэмээн онцлов.

## 840 ЧИНГЭЛЭГ АЧАА БУЮУ 25,253 ТОНН АЧААГ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ АЖИЛД ОРОЛЦЛОО

Зэвсэгт хүчний 336 дугаар анги

Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссын шийдвэрийн хүрээнд ЗХЖШ-ын даргын тушаалаар Улаанбаатар төмөр зам, Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн захирагчтай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан билээ. Эл гэрээний дагуу ангийн захирагчийн тушаалаар тус ангийн 200 хүний бүрэлдэхүүн 2 ээлжээр Замын-Үүд боомтод 67 хоногийн хугацаанд ажиллалаа.

Тодруулбал, УБТЗ-ын харьяа Замын-Үүд боомтын

1, 3 дугаар талбайд нийт 840 чингэлэг буюу 25,253 тонн ачааг автомашинаас вагонд шилжүүлэн ачиж Монгол Улсын зах зээлд үүсээд байсан түүхий эд, бараа материалын хомсдол, үнийн өсөлтийг бууруулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан юм.

Мөнтусангийнминомётын батареиг Монгол Улсын баатар Д.Данзанваанчигийн нэрэмжит болгохтой холбогдуулан нэрэмжит буланг шинээр хийх ажлыг ахмад В.Цогбадрах 2 сарын хугацаанд хийж дуусгалаа.

Дэслэгч Ч.БОДЬГЭРЭЛ



### МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН  
374.040 +139

ВАКЦИНЖУУЛАЛТ  
2,153,968 +560

НАС БАРСАН  
1,947 +3

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН  
6601 +111

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ  
77

ЭДГЭРСЭН  
6397

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 268,068,447

Эдгэрсэн

Нийт: 241,266,386

Нас барсан

Нийт: 5,294,421

цаг үе, үйл явдал

## “НӨХӨРСӨГ ЭНХИЙГ САХИУЛАГЧ” ӨДӨРЛӨГ, ТӨРСӨН ӨДРИЙН БАЯРТАЙ 12 ДУГААР САР



спортын өндөр амжилтыг хүссэн юм.

Өдөрлөгийн хүрээнд гар бөмбөгийн болон зуун буудалт даамны аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан юм. Тэмцээнд нийт 60 гаруй цэргийн алба хаагч оролцсоноос гар бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээний тэргүүн байрт 11 дүгээр ээлжийн мотобуудлагын батальоны дэслэгч О.Баттогтох ахлагчтай нэгдүгээр баг, дэд байрт тус батальоны ахлах ахлагч М.Мөнх-Эрдэнэ ахлагчтай

БНӨСУ-д НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний 10 болон 11 дүгээр ээлжийн мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүний амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, харилцан туршлага солилцох, нөхөрсөг харилцааг бий болгох зорилгоор “Нөхөрсөг энхийг сахиулагч” өдөрлөгийг энэ сарын 5-ны өдөр Бентью хот дахь Хубилай баазад зохион байгууллаа.

Энэхүү өдөрлөгийг Монгол Улсын Зэвсэгт хүчний 11



дүгээр ээлжийн мотобуудлагын батальоны захирагч хурандаа О.Заяат нээж, нийт тамирчдад

хоёрдугаар баг шалгарсан юм. Мөн зуун буудалт даамны аварга шалгаруулах тэмцээний эрэгтэй төрөлд 2 дугаар мотобуудлагын ротын ахлах ахлагч Г.Цэнд-Аюуш, эмэгтэй төрөлд байлдааны хангалтын ротын ахлах ахлагч Ц.Гэрэлтуяа нар тэргүүлж үнэ бүхий зүйлээр шагнууллаа.

Түүнчлэн батальоны бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, урам зоригор дэмжих зорилгоор 11 дүгээр сард төрсөн алба хаагчдын төрсөн өдрийн баярыг тэмдэглэв.

Ахлах дэслэгч Ц.БАДАМСҮРЭН



## ГАР БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭНИЙ ШИЛДГҮҮД ТОДОРЛОО



Зэвсэгт хүчний 325 дугаар анги

Ангийн захирагчийн нэрэмжит “Чандмань өлзий-III” гар бөмбөгийн лигийн тэмцээнийг энэ сарын 1-5-ны өдрүүдэд зохион байгууллаа. Бие бүрэлдэхүүний бие бялдрыг гар бөмбөгийн спортоор дамжуулан хөгжүүлэх, залуучуудын ур чадварыг нээн илрүүлэх, Зэвсэгт хүчин, Агаарын цэргийн аварга шалгаруулах спорт тоглоомын төрөлд оролцох ангийн шигшээ багийг бүрдүүлэхэд тус тэмцээний зорилго чиглэв. Тэмцээнд тус бүр 16 хүнтэй эрэгтэй 8 баг, мөн 9 хүнтэй эмэгтэй 5 баг буюу нийт 171 тамирчин оролцсоноос

I байрт дэд хурандаа Т.Армия дасгалжуулагчтай “Этүгэн” баг, II байрт хурандаа Г.Чулуунзагд дасгалжуулагчтай “Лидер” баг, III байрт дэд хурандаа Д.Хишигбаатар

дасгалжуулагчтай “Гарьд” баг, эмэгтэйчүүдийн төрөлд I байрт дэд ахлагч Б.Энхдалай дасгалжуулагчтай “Mikasa” баг, II байрт ахлах ахлагч Ж.Болор-Эрдэнэ дасгалжуулагчтай “Отгоргүй” баг, III байрт дэд хурандаа Өнөржаргал дасгалжуулагчтай “Соёмбо” баг тус тус шалгарч шилжин явах цом, өргөмжлөл, алт, мөнгө, хүрэл медаль, үнэ бүхий зүйлсээр шагнуулав.

Эл тэмцээнийг ангийн захирагч хурандаа Г.Чулуунзагд санаачлан ийнхүү гурав дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулсан бөгөөд тэмцээний шагнал урамшууллыг тэрээр хувиасаа гаргаж, спортыг дэмжин ажилладаг юм.



## ШИНЭХЭН ДАЙЧДАДАА ХӨГЖМИЙН БОЛОВСРОЛ ОЛГОЖ ЭХЭЛЛЭЭ



Зэвсэгт хүчний 326 дугаар анги Хөгжмийн тодорхой мэдлэгтэй, үлээвэр

хөгжим сурах сонирхолтой авьяаслаг хугацаат цэргийн алба хаагчдаас 15 цэргийн алба хаагчийг сонгон

шалгаруулж тэдэнд цэргийн мэргэжлийн хичээлээс гадна тусгай хөтөлбөрийн дагуу хөгжмийн боловсрол олгож эхэллээ.

Тус ангийн анхны хөгжмийн удирдаачаар ажиллаж байсан СТА бэлтгэл ахлах ахлагч Ч.Гантөмөр, Д.Одбаяр нарыг урьж тус сургалтыг зохион байгуулж байна. Сургалтад хамрагдаж буй дайчид амжилттай сайн суралцвал цэргийн албанд хөгжимчнөөр алба хаах, ангийн ёслол, хүндэтгэлийн арга хэмжээнд оролцох, цаашлаад ангидаа хөгжимчин болох боломж байдаг тул хугацаат цэргийн алба хаагчид сэтгэгдэл өндөр шамдан суралцаж байна.

## “АРХИНЫ ХЭРЭГЛЭЭГҮЙ ШИНЭ ҮЕ” ТӨСЛИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД



Зэвсэгт хүчний 032 дугаар анги Ангийн нийт бие бүрэлдэхүүнд Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Монголын эрэгтэйчүүдийн хөгжлийн нийгэмлэгийн хамтран зохион байгуулж буй “Архины хэрэглээгүй шинэ үе” төслийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ҮАБЗ-ийн Аюулгүй байдлын шинжээч, МУСГЗ,

Аюулгүй байдлын ухааны доктор, соён гэгээрүүлэгч, Монголын эрэгтэйчүүдийн хөгжлийн нийгэмлэгийн ерөнхийлөгч Ж.Цогтсугар “Аюулгүй байдал ба оюун тархины нууц”, Монголын эрэгтэйчүүдийн хөгжлийн нийгэмлэгийн ерөнхий менежер МУСТА Г.Батбаяр “Архины хэрэглээгүй шинэ үе”, уг төслийн санаачлагч Оюуны хөгжлийн төвийн ерөнхий менежер Б.Жавзандаулам “Хайрын таван бэлэг” сэдвээр лекц, уулзалт ярилцлагыг зохион байгуулж, шүлэг, ая дууны мөндчилгээг дэвшүүллээ.

Тус төслийн хүрээнд уригдан ирсэн хүндэт зочдод ангийн удирдлага, хамт олон талархсан сэтгэлээ илэрхийлж, гарын бэлэг гардуулсан бөгөөд дээрх уулзалтад бие бүрэлдэхүүн идэвх санаачилгатай оролцсон ач холбогдол бүхий арга хэмжээ боллоо.

Ахмад О.ГЭРЭЛЗАЯА

## АНГИЙН ШИЛДЭГ ТЕННИСЧИД ТОДРОВ



Зэвсэгт хүчний 350 дугаар анги Монгол Улсад Санхүү эдийн засгийн алба үүсэн байгуулагдсаны 110 жилийн ой, Монголын санхүүчдийн

баярын өдрийг тохиолдуулан дэд хурандаа Ц.Бямбасүрэн даргатай Санхүүгийн албанаас ангийн аварга шалгаруулах “Ширээний теннис”-ний тэмцээнийг

зохион байгууллаа.

Тэмцээний ганцаарчилсан төрөлд 24 тамирчин, хосын төрөлд 9 багийн 18 тамирчин оролцсоноос ганцаарчилсан төрлөөр тэргүүн байрт Б.Эрхэмбаяр, дэд байрт хошууч Б.Хүрэлчулуун, гутгаар байрт ахлагч Н.Хуягбаатар нар шалгарлаа. Харин хосын төрлөөр тэргүүн байрт Б.Эрхэмбаяр, Э.Дуламсүрэн, дэд байрт ахлагч Н.Хуягбаатар, М.Болортуяа, гутгаар байрт хошууч Б.Хүрэлчулуун, Ө.Ханд нар тус тус шалгарсан юм.

## ОХУ-Д ХҮССЭН СУРГУУЛЬДАА ТЭТГЭЛГЭЭР СУРАЛЦАХ ЭРХИЙН БИЧГЭЭР ...

Нийслэлийн Тэргүүний Ерөнхий Боловсролын “Тэмүүжин Өрлөг” сургуулийн 12А ангийн сурагч О.Шаравжамц нь Улаанбаатар хот дахь Орос ордны дэргэдэх Орос хэлний төвүүдийн сурагчдын дунд зохион байгуулсан орос хэл болон мэргэжлийн суурь хичээл болох химийн олимпиадад оролцож тэргүүн байр эзлэн ОХУ-д хүссэн сургуульдаа тэтгэлгээр суралцах эрхийн бичгээр шагнагдлаа. Түүнд Москва хотын Сечёновын нэрэмжит Анагаах ухааны их сургуульд мэс заслын их эмч мэргэжлээр суралцах эрхийн бичгийг ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Зөвлөх, Россотрудничество Агентлагийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын тэргүүн энэ сарын 6-ны өдөр гардуулсан юм.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ Батлан хамгаалах яам Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС “Соёмбо” сонин “Дуулга” студи

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ. \* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхтэй, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ. \* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018 Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)